



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/635

Хэрлэн сум

Зөвлөгөөн зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны хорьдугаар хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын салбарын удирдах ажилтан, багш нарын хамтран хөгжих, харилцан туршлага солилцох “Бид Хэнтийн багш” зөвлөгөөнд зориулж 14,000,000 (арван дөрвөн сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Зөвлөгөөнд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын эрүүл мэнд, боловсролын салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү,төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, арга хэмжээнд хяналт тавьж, удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 12 дугаар сарын 13-ны
А/635 дугаар захирамжийн хавсралт

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Завсарлагааны цайны зардал (цай, кофе, пицца, сендвич)	ш	300	12000	3600000
2	Цэвэр ус	ш	150	1000	150000
3	Хоолны зардал	ш	150	35000	5250000
4	Хан бүргэдэй ресторан түрээсийн зардал	өдөр	1	5000000	5000000
	Зардлын дүн				14000000